

“Эрдэнэс –Таван Толгой” ХК –ийн уурхайд зочлох зочин, иргэд дараах журмуудтай танилцсан байх шаардлагатай.

1.0 ЗОРИЛГО БА ХАМРАХ ХҮРЭЭ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь “Эрдэнэс - Таван Толгой” ХК-ийн (цаашид компани гэх) ээлж солилцох ажилтнуудыг Улаанбаатар хот, Даланзадгад, Цогтцэций сум, уурхайн ажилчдын хотхон, уурхайн бусад барилга байгууламжуудын хооронд тээвэрлэх эсхүл компаниас зохион байгуулсан аялал, зугаалгын арга хэмжээний үед автобусаар зорчих үеийн аюулгүй ажиллагаа болон хэв журмын асуудлыг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү журам нь компанийн нийт ажилтан болон тухайн зорчигч тээврийн хэрэгслээр зорчиж байгаа гэрээт ажилчид, зочид зэрэг бүх хүнд нэгэн адил хамаарна.
- 1.3 Энэ журам нь “ЕТТ-ОHS-12-A1 - Аялалын журам”-ын салшгүй нэг хэсэг байна.

2.0 АВТОБУСААР ЗОРЧИХ ЖУРАМ

2.1 Ерөнхий шаардлага

- 2.1.1 Уурхайн өдөр тутмын ээлж солилцохоос бусад зорилгоор хол замд зорчих бол бүх ажилтнууд “ЕТТ-ОHS-CP12-A1 - Аялалын журам”-тай танилцаж 1-р хавсралт буюу ЕТТ-ОHS-CF08-A1 - Аялалын зааварчилгааны хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулна.
- 2.1.2 Мөн журмын 2-р хавсралт буюу ЕТТ-ОHS-CF11-A1 маягыг уг аялалын удирдагч эсхүл зохион байгуулагч буюу захиргааны мэргэжилтэн урьдчилан бөглөж аялалыг эхлүүлэх зөвшөөрөл өгөх үүрэгтэй.
- 2.1.3 Автобусны жолооч зорчигч нарт аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, техникийг бүрэн бүтэн байдлыг шалгах ажлыг компанийн болон уурхайн захиргаа, хүний нөөцийн ажилтнууд хариуцна.
- 2.1.4 Захиргаанаас томилсон ажилтан эсхүл жолооч нь Улаанбаатар хотын болон уурхайн хүний нөөцийн болон захиргааны холбогдох ажилтнуудтай харилцаатай явж замын мэдээллийг тогтмол цагуудад өгч байна.
- 2.1.5 Аялах зорчих ажилтнуудын бүртгэл, ирц, замын хоолны төлбөрийн асуудлыг захиргаа, хүний нөөцийн хэлтэс хариуцан зохицуулна.
- 2.1.6 Улаанбаатар-Цогтцэций, Цогтцэций-Улаанбаатар чиглэлд зорчих автобус нь хоолны завсарлагаар Мандалговьд 1 цаг зогсоно.
- 2.1.7 Аяллын явцад зорчигч тээвэрлэж яваа автобусанд эвдрэл, гэмтэл гарч саатах, цаг агаарын онц аюултай үзэгдэл болсон тохиолдолд компанийн захиргаанаас холбогдох арга хэмжээг шуурхай авна.

2.2 Зорчигчийн үүрэг

- 2.2.1 Аялалд гарахын өмнө зорчин явах ажилтнууд тухайн улиралд тохируулан хувцсаа бэлдсэн байх үүрэгтэй.
- 2.2.2 Автобус хөдлөх хуваарьт хугацаанаас 30 минутын өмнө ачаагаа өгч явахад бэлэн болсон байх үүрэгтэй.
- 2.2.3 Зорчигч бүр өөрийн ажлын үнэмлэх, биеийн байцаалтыг биедээ авч явна.

- 2.2.4 Ажилтан нь автобусанд ээлж дараагаараа, нэг нэгээрээ бууж, сууна.
- 2.2.5 Ажилчид автобусны шатаар өгсөж, уруудахдаа заавал гурван цэгээр хүрэлцэх дүрмийг баримтална.
- 2.2.6 Аялал эхлэхийн өмнө хаалганы дэргэд болон бууж, суух замд саад болохоор зогсох суухыг хориглоно.
- 2.2.7 Жолооч хөдөлгөөнөө эхлэхээс өмнө хүн бүр суудалдаа сууж суудлын даруулгаа хийсэн байна.
- 2.2.8 Жолоочийн ажил үүрэгтэйгээ холбоотой тавьсан шаардлагыг биелүүлж явах үүрэгтэй.
- 2.2.9 Ажилчид нь автобус замын хөдөлгөөнд оролцож явах үед ямарч тохиолдолд жолоочийн анхаарлыг өөр зүйлд сарниулах, яаруулах зэрэг үйлдэл хийж болохгүй.
- 2.2.10 Ажилчид бие биедээ шаардлага тавьж зөв, соёлтой харьцааг эрхэмлэнэ.

2.3 Автобусны жолоочийн үүрэг

- 2.3.1 Автобусны жолооч нь Захиргааны хэлтсээс гаргасан зөвшөөрөгдсөн маршрутын дагуу явна.
- 2.3.2 Автобусны жолооч нь ажилчдыг автобусанд орсны дараа хаалгаа бүрэн хааж хөдөлгөөнөө эхлүүлэх ба бүрэн зогсолт хийсний дараа автобуснаас буулгана.
- 2.3.3 Автобусны жолооч нь ажилчдын ая тухтай зорчих, халтирах, бүдрэх зэрэг аюулаас сэргийлэх нөхцлийг бүрдүүлж автобусны суудал, заал, орох, гарах хаалганы гишгүүр зэргийг тогтмол цэвэрлэнэ.
- 2.3.4 Автобусны жолооч нь шөнийн цагаар явахдаа заалны гэрлийг тогтмол асааж явна.
- 2.3.5 Автобусны жолооч нь замбн хөдөлгөөний дүрмийг чанд мөрдөж аялалын аюулгүй байдлыг хангаж жолоодох үүрэгтэй.

3.0 ХОРИГЛОХ ЗҮЙЛ

3.1 Жолоочид хориглох зүйл

- 3.1.1 Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх,
- 3.1.2 Автобусанд тамхи татах,
- 3.1.3 Ажлын чиглэл зааварчилгааг санаатай зөрчих,
- 3.1.4 Суудлын бүс зүүлгүй жолоодох,
- 3.1.5 Автобусанд удирдлагын зөвшөөрөлгүйгээр онцгой байдлаас бусад тохиолдолд гадны хүн суулгах,
- 3.1.6 Онцгой байдлаас бусад нөхцөлд жолоог бусдад шилжүүлэх,
- 3.1.7 Зорчигчын тоог суудлын тооноос хэтрүүлж тээвэрлэхийг хориглоно.

3.2 Зорчигчид хориглох зүйл

- 3.2.1 Тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцож байх үед ямар ч тохиолдолд жолоочийн анхаарлыг сарниулах, яаруулах;
- 3.2.2 Хоолны завсарлаганд зарцуулах ¹ цагийг хэтрүүлж зогссон газраар дэмий сэлгүүцэх, хоолноос удаж ирэх;
- 3.2.3 Аяллын явцад тээврийн хэрэгсэл түр зогсох үед компанийн журам зөрчин согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх;
- 3.2.4 Тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцож байх үед тамхи татах, суудлаасаа босч явах;
- 3.2.5 Автобусны суудалд давхарлаж суух;
- 3.2.6 Аяллын явцад суурин газар түр зогсолт хийх үед бусаддаа мэдээлэлгүй ганцаар болон хэсэг бүлгээр өөр тийш явах;
- 3.2.7 Бусдын амгалан тайван байдлыг алдагдуулан танхайрах, зодолдох, ноцолдох, бусад хэв журмын зөрчил гаргах;
- 3.2.8 Компанийн захиргаанаас гаргаж өгсөн болон орон нутгийн хүн тээврийн автобус, машинаас өөр унаагаар дүр мэдэн, зөвшөөрөлгүй аялал хийхийг тус тус хориглоно.

4.0 ХАРИУЦЛАГА

- 4.1 Уурхайн нийт ажилтан нь компанийн захиргаанаас баталж өгсөн маршрут, гаргаж өгсөн унаагаар яваагүйн улмаас осолд өртөх, бусад өөрийн буруугаас үүссэн аливаа асуудлыг ажилтан өөрөө бүрэн хариуцна.
- 4.2 Ажилтан нь аяллын явцад зөрчил гаргавал компанийн “Согтууруулах ундаа, мансууруулах бодисын талаар баримтлах бодлого, журам”, “Аюулгүй ажиллагааны сахилгын журам”-ын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЭЛТЭС

¹ Хэрэв ажилтны хариуцлагагүйгээс автобус илүү хугацаагаар хүлээх бол автобусны сул зогсолтын алдагдал төлбөрийг тухайн ажилтнаар төлүүлнэ.